

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД

0-5 настай хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн түвшинг тогтоох судалгааны дүнгээс

*Болор Б.¹, Энхтуяа П.¹, Цэгмэд С.¹, Оюунчимэг Д.¹, Золзаяа Д.¹, Болормаа И.¹,
Чинзориг Б.¹, Амартүвшин Т.², Сувд Б.¹*

*¹Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, ²Монгол улсын их сургууль
Email: b.bolor77@yahoo.com*

Abstract

**Satisfaction of health care and services for parents and guardians
with 0–5 years-old children**

*Bolor B.¹, Enkhtuya P.¹, Tsegmed S.¹, Oyunchimeg D.¹, Zolzaya D.¹, Bolormaa I.¹, Chinzorig B.¹,
Amartuvshin T.², Suvd B.¹*

*¹National Center for Public Health, ²National University of Mongolia
Email: b.bolor77@yahoo.com*

Introduction

Within the framework of health sector reform, the development of the organization, the responsibility of doctors and medical professionals, and the improvement of ethics, quality and safety of care and services are top priorities. Customer satisfaction is important for the implementation of this operation based on results and quality. The WHO Recommendation states that health professionals have a key role to play in providing information and advice to citizens and their families on how to prevent, mitigate and address air pollution, and how to inform the general public and decision-makers. ADB, the Ministry of Health, and UNICEF report that information and promotional materials on air pollution prevention are scarce and do not provide advice to clients. Therefore, it is the reason for conducting a survey to determine the level of satisfaction of clients receiving child health care.

Materials and methods

The survey data were collected using quantitative and qualitative research methods. In this study, totally 1160 guardians of children aged 0-5 participated from Songinokhairkhan and Bayanzurkh district and Bayankhongor aimag center. The overall satisfaction of health services is calculated using the three dimensions namely: satisfaction with health service, operation and environment of Health Organization. Satisfaction scores were assessed using an even-point scale. These are “Very Dissatisfied-1 point”, “Dissatisfied-2 point”, “Satisfied-3 point”, “Very satisfied-4 point”. The results were calculated after entering the survey data into SPSS-23, creating a database, and performing error control. Research methodology discussed at the meeting of the Academic Council of the National Center for Public Health on December 25, 2019, and the methodology was approved by the Medical Ethics Committee of the MOH (Stagnant №2).

Results

84.7 percent of the respondents were parents of children aged 0-5 years. Their average age is 34, most of them have higher education, and 43.0 percent of them have a household income of 500,000-1 million MNT. Guardians of children aged 0-5 years in Bayanzurkh District were “dissatisfied” with the Family Health Center’s dressing room, wardrobe, toilet and parking lot. Guardians of children aged 0-5 years in Songinokhairkhan district were “dissatisfied” in the parking lot and toilet of the health organization. Guardians of children aged 0-5 years in Bayankhongor aimag were satisfied with the services, operation and environment of the health organization. Studies have shown that 76.5 percent of the guardians did not receive air pollution risk training. As for difficulties in preventing air pollution, 31.4 percent of the surveyed population answered that they cannot change their living and working environment to prevent air pollution.

Conclusion

It shows the health care organizations need to improve the hospital environment as well as to provide training how to protect children from air pollution risk for guardians.

Key word: Client satisfaction, guardians, primary care, health services, air pollution, Ulaanbaatar

Pp. 37-45, Figure 1, Tables 4, References 16

Үндэслэл

Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтний хариуцлага, ёс зүй, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах нь нэн тэргүүний асуудал бөгөөд үйл ажиллагааг үр дүнд суурилсан, чанартай хэрэгжүүлэхэд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж чухал юм. Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 [1], “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны аргачлал батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2014 оны 13 тоот тушаал [2]-аар Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг судлах талаар заасан байдаг. ЭМЯ-ны харьяа байгууллагуудын дунд 2018 онд хийгдсэн “Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа”-гаар Амбулатороор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл Амбулатори болон хэвтэн эмчлүүлэгчийн сэтгэл ханамж СЭМҮТ 90.5 хувь, УГТЭ-88.7 хувьтай хамгийн өндөр сэтгэл ханамжтай, СХНЭ-56.1 хувь, ЧДЭМТ-66.6 хувьтай сэтгэл ханамж дунджаас доогуур байсан бөгөөд судалгааг байгууллага бүр тогтмол зохион байгуулж үйлчлүүлэгч болон ажиллагсдын сэтгэл ханамжийг хэмжих тогтолцоог бий болгох, жилд 1-2 удаа хөндлөнгийн байгууллагаар судалгааг хийлгэх зөвлөмжийг гаргажээ [3].

Манай улсад бага насны хүүхдийн өвчлөл, эндэгдлийн зонхилох шалтгаан нь амьсгалын замын цочмог өвчнүүд (ханиад, уушгины хатгалгаа) суулгалт халдвар, сульдаа, цус багадалт зэрэг эмгэгүүд байдаг [4,5,6]. Хүүхдийн амьсгалын замын өвчлөл болон тархины хөгжилд хүрээлэн буй орчны зарим хүчин зүйл тухайлбал дотоод болон гадаад орчны агаарын бохирдол ихээхэн нөлөөлөл үзүүлж буйг нилээд хэдэн судалгаагаар тогтоосон байдаг [7,8,9]. Эрүүл мэндийн мэргэжилтнүүд иргэд, тэдгээрийн гэр бүлд агаарын бохирдолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, асуудлыг шийдвэрлэх арга замын талаар зөвлөгөө, мэдлэг олгох, нийт хүн ам болон шийдвэр гаргагч нарт мэдээлэл хүргэхэд ихээхэн үүрэгтэй оролцох талаар ДЭМБ-ын зөвлөмжид тусгасан байдаг [10]. Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн иргэдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг сайжруулах, хянах нь чухал байна [11]. 2019 онд Улаанбаатар хот болон Баянхонгор аймагт хийсэн судалгаагаар эмч, мэргэжилтнүүд өвлийн улиралд ажлын ачаалал ихтэй байдгаас үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгөх явдал хангалтгүй байдгийг тогтоожээ [12]. Азийн

хөгжлийн банкны тайланд агаарын бохирдол түүний нөлөөллөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл сурталчилгааны материал ховор, үйлчлүүлэгчдэд энэ талаарх зөвлөгөөг огт өгдөггүй талаар дурьдсан байна [13]. Иймд эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг тогтоох судалгаа хийх шаардлагатай байна.

Зорилго

0-5 настай хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийг үнэлэх

Зорилт

Үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн түвшинг тогтоох;

0-5 настай хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр агаарын бохирдлоос сэргийлэх зөвлөгөө авахад тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлох;

Материал арга зүй

Судалгааны мэдээг цуглуулахад тоон болон чанарын судалгааны аргуудыг ашиглан нэг агшингийн загвараар явуулав. Судалгааг НЭМҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хурал, ЭМЯ-ны Анагаах ухааны ёс зүйн хорооны хурлаар (Тогтоол №2) хэлэлцүүлж баталсан арга, аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн. Судалгаанд зорилтот түүвэрлэлтийн аргыг сонгосон бөгөөд Улаанбаатар хотын СХД, БЗД болон Баянхонгор аймгийн төвийн 0-5 насны хүүхдийн нийт 1120 асран хамгаалагч хамрагдав. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг тогтоохдоо 0-5 насны хүүхдийн асран хамгаалагчдыг асуумж судалгаанд хамруулсан. Эрүүл мэндийн үйлчилгээний нийт сэтгэл ханамжийг тооцохдоо Эрүүл мэндийн үйлчилгээний сэтгэл ханамж (үзлэг, эмчилгээ нь үр дүнтэй, шаардлагад нийцсэн эсэх, зөвлөгөө нь ойлгомжтой, хэрэгцээтэй байсан эсэх зэрэг), ЭМБ-ын үйл ажиллагаа болон орчин нөхцлийн талаарх сэтгэл ханамжийн байдлаар үр дүнг харьцуулан гаргав. Судалгаанд тэгш тоон хэмжээс (even-point scale)-ийг ашиглан сэтгэл ханамжийн оноог үнэлсэн. Үүнд: “Огт сэтгэл ханамжгүй -1-1.49 оноо”, “Сэтгэл дундуур -1.5-2.49 оноо”, “Сэтгэл хангалуун -2.5-3.49 оноо”, “Маш их сэтгэл ханамжтай-3.5-4 оноо”, Сэтгэл ханамжийг тодорхойлох үзүүлэлт бүрийн сэтгэл ханамжийн оноо нь тухайн үзүүлэлтэд хамаарах

асуулт тус бүрт авсан онооны дундаж утгаар тодорхойлогдсон.

Сэтгэл ханамжийн оноо

Чанарын судалгааг ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаар урьдчилан боловсруулсан удирдамжийн дагуу 0-5 насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч, өрх болон аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвийн удирдах ажилтнууд нийт 40 хүнтэй ярилцаж эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд агаарын бохирдлоос сэргийлэх зөвлөгөө өгөхөд тулгамдаж буй бэрхшээл, боломжийг судалсан. Судалгааны тоон мэдээллийг SPSS-23 статистикийн программд шивж, мэдээллийн бааз үүсгэн,

алдааг хянах зэрэг үйлдлүүдийг гүйцэтгэсний дараа үр дүнгийн тооцооллыг хийсэн.

Үр дүн

Асран хамгаалагчдын ӨЭМТ-ийн эрүүл мэндийн үйлчилгээ тус бүрт өгсөн сэтгэл ханамжийн оноо 2.98-3.29 буюу “сэтгэл хангалуун” байна. Судалгаанд оролцогчид аймаг, дүүргийн эрүүл мэндийн үйлчилгээнд 2.86 (95%ИХ: 2.79-2.92) буюу “сэтгэл хангалуун”, үйл ажиллагаанд 2.85 (95%ИХ 2.8-2.93) буюу “маш их сэтгэл ханамжтай”, орчин нөхцөлд 2.62 (95%ИХ 2.57-2.67) буюу “сэтгэл хангалуун” байдаг хэмээн хариулжээ (Table 1).

Table 1. Average satisfaction score for Health Organizations' care and service

Health Organizations' care and service	Bayanzurkh district		Songinokhairkhan district		Bayankhongor aimag		Total	
	Family health center	District health center	Family health center	District health center	Family health center	Aimag health center	Family health center	Aimag-District health center
Health service	3.06	2.82	3.16	2.87	3.27	3.08	3.11	2.86
Activities of medical institutions	3.0	2.85	3.1	2.88	3.22	3.01	3.05	2.85
Health facility environment	2.53	2.57	2.71	2.63	3.08	3.04	2.64	2.62

Note: 1-1.49 “very dissatisfied”, 1.5-2.49 “dissatisfied”, 2.5-3.49 “satisfied”, 3.5-4 “very satisfied”

Тусламж үйлчилгээ

Судалгаанд оролцогчдын 98.0 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвөөр, 55.6 хувь нь аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн ба Баянхонгор аймгийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн хүн амын хувь аль ч шатлалд өндөр байлаа. Асран хамгаалагчдын ӨЭМТ-ийн үйлчилгээ (хүүхдийн үзлэг, эмчилгээ,

эмчийн зөвлөгөө ойлгомжтой, хэрэгцээтэй байсан эсэх)-нд өгсөн сэтгэл ханамжийн дундаж оноо 3.11 (95%ИХ 3.08-3.14) буюу “сэтгэл хангалуун”, Аймаг дүүргийн ЭМТөвийн үйлчилгээнд өгсөн сэтгэл ханамжийн дундаж оноо 2.86 (95%ИХ 2.79 -2.92) буюу “сэтгэл хангалуун” байна (Table 2).

Table 2. Average score for satisfaction with health care services, by survey area

Health care services	Bayanzurkh district		Songino-khairkhan district		Bayankhongor aimag		Total	
	Family health center	District health center	Family health center	District health center	Family health center	Aimag health center	Family health center	Aimag-District health center
Satisfaction with the advice was understandable	3.1	-	3.2	-	3.2	-	3.1	-
Satisfaction with the information you get from the consultation	3.07	-	3.1	-	3.3	-	3.1	-
Satisfaction with the examination and treatment were effective and in accordance with the requirements	2.9	2.8	3.1	2.8	3.2	3.0	3.0	2.8

Note: 1-1.49 "very dissatisfied", 1.5-2.49 "dissatisfied", 2.5-3.49 "satisfied", 3.5-4 "very satisfied"

Чанарын судалгаанд хамрагдсан зарим асран хамгаалагчид ӨЭМТ-ийн үйлчилгээнд "сэтгэл дундуур" байдаг гэжээ.

ӨЭМТ-ийн үзлэг, эмчилгээ, зөвлөгөөнд сэтгэл дундуур байдаг. Учир нь тэд шаардлагатай зөвлөгөө мэдээллийг хангалттай сайн өгч чаддаггүй. ӨЭМТ-ийн эрүүл мэндийн ажилтнууд мэдлэг, ур чадвараа сайжруулах шаардлагатай гэж боддог. Дүүргийн эмнэлгийн эмч, ажилчид илүү чадварлаг байдаг. Эмнэлгийн орчин нөхцөл хангалтгүй тухайлбал хүлээлгийн заал, өлгүүр гэх зүйл ӨЭМТ-д байдаггүй.

СХД-ийн асран хамгаалагч У

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа

Асран хамгаалагчдын эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд (цагийн хуваарь, үйлчилгээний төлбөр, тоног төхөөрөмжийн хүрэлцээ, эмч, мэргэжилтэний харилцаа, мэдлэг чадвар) өгсөн сэтгэл ханамжийн оноо ӨЭМТ-д 2.8-3.1, аймаг, дүүргийн ЭМТ-д 2.7-3.0 буюу "сэтгэл хангалуун" байна. Эдгээр үзүүлэлтэд байршлын ялгаа ажиглагдаагүй болно. 0-5 насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчид ӨЭМТ-ийн тоног төхөөрөмж, аймаг дүүргийн ЭМТ-ийн үйлчилгээний цагийн хуваарьт сэтгэл ханамжийн бага оноог өгсөн байна (Table 3).

Table 3. Average satisfaction score of the operations of Health organization, by area covered by the survey

Operations of the Health organization	Bayanzurkh district		Songinokhairkhan district		Bayankhongor aimag		Total	
	Family health center	District health center	Family health center	District health center	Family health center	Aimag health center	Family health center	Aimag-District health center
Service schedule	2.9	2.8	3.0	2.7	3.1	2.9	3.0	2.7
Pediatric examination	3.1	-	3.2	-	3.2	-	3.1	-
Service fee	3.0	2.9	3.1	3.0	3.2	3.0	3.1	2.9
Adequacy of service tools	3.0	2.8	3.2	2.8	3.2	2.9	2.8	2.8
Employee communication skill	2.8	2.8	2.8	2.8	3.0	2.9	3.1	2.8
Knowledge and skills of employees	3.0	2.9	3.1	3.0	3.3	3.0	3.0	3.0

Note: 1-1.49 “very dissatisfied”, 1.5-2.49 “dissatisfied”, 2.5-3.49 “satisfied”, 3.5-4 “very satisfied”

Эрүүл мэндийн байгууллагын орчин нөхцөлд оролцогчдын сэтгэл ханамж

Асран хамгаалагчдын эрүүл мэндийн байгууллагын орчин нөхцөлд өгсөн сэтгэл ханамжийн дундаж оноо 2.6-аас их буюу “сэтгэл хангалуун” байгаа хэдий ч аймаг, нийслэлд

ялгаатай байлаа. Тухайлбал үйлчлүүлэгчид аль ч дүүргийн ЭМБ-ын ариун цэврийн өрөөний хүрэлцээтэй байдал, машины зогсоолд 2.49-оос бага буюу “сэтгэл дундуур” гэсэн үнэлгээг өгч байсан бол энэ үзүүлэлт Баянхонгор аймагт 2.9-оос их буюу “сэтгэл хангалуун” байна (Table 4).

Table 4. Average score of satisfaction with the environment of the health organization, by survey area

Environment of the Health Organization	Bayanzurkh district		Songinokhairkhan district		Bayankhongor aimag		Total	
	Family health center	District health center	Family health center	District health center HC	Family health center	Aimag health center	Family health center	Aimag-District health center
Cleanliness of the hospital environment	3.0	2.8	3.1	2.9	3.3	3.1	3.0	2.9
The comfort of the waiting room	2.7	2.7	2.8	2.7	3.1	3.0	2.7	2.7
Adequacy of changing rooms and hangers	2.4	2.5	2.5	2.6	2.8	2.9	2.5	2.6
Possibility to use the bathroom	2.2	2.4	2.5	2.4	2.9	2.9	2.4	2.4

Adequate parking	2.2	2.2	2.4	2.4	3.1	3.0	2.3	2.3
Note: 1-1.49 "very dissatisfied", 1.5-2.49 "dissatisfied", 2.5-3.49 "satisfied", 3.5-4 "very satisfied"								

Агаарын бохирдлоос сэргийлэх зөвлөгөө авахад тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлсон дүн

Судалгаанд оролцогчдын 88.5 хувь нь агаарын бохирдлын эрсдэлийн талаарх мэдээллийг өөрсдөө олж авдаг гэжээ. Судалгаанд

оролцогчдын 59.8 хувь нь агаарын бохирдлын эрсдэлийг бууруулах талаарх мэдээллийг телевизээс авсан байна. Энэ үзүүлэлт Баянхонгорт 66.9 хувь, СХД-т 69.8 хувь, БЗД-т 52.3 хувьтай байна (Table 5).

Table 5. Receipt of information on air pollution risk reduction, information sources, by survey area

Sources	Bayanzurkh district	Songinokhairkhan district	Bayankhongor aimag	Total
	%	%	%	%
Health workers consultation	27.8	31.4	38.1	28.6
Training	7.9	8.9	26.3	8.7
IEC materials	12.3	16.8	25.7	13.9
Television	52.3	69.8	66.9	59.8
Internet	55.9	60.3	52.3	56.1
Family, friends	12.4	12.9	19.4	12

Чанарын судалгаанд хамрагдсан асран хамгаалагчдын дийлэнх нь агаарын бохирдлоос

хэрхэн сэргийлэх талаарх зөвлөгөөг эмч, эмнэлгийн мэргэжилтнээс авч байгаагүй гэжээ.

Хүүхдээ үзүүлэх үедээ эмчээс агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл авч байгаагүй. Манай хорооны хувьд Улаанбаатар хоттой харьцуулахад агаарын бохирдол харьцангуй бага байдаг. Харин сүүлийн үед агаарын бохирдол ихсэж байгаа. Иймд эмч, эмнэлгийн ажилтнууд урьдчилан сэргийлэх чиглэлийн зөвлөгөө өгч байвал сайн байна.

СХД-ийн 21-р хорооны асран хамгаалагч

Эмч, эмнэлгийн ажилтнаас агаарын бохирдлоос хамгаалах зөвлөгөө авч байгаагүй. Үзлэг хийх үед амаар зөвлөгөө өгөх эсвэл хэвлэмэл хуудсаар зөвлөгөө авч байвал болно.

БЗД-ийн 10 сартай хүүхдийн асран хамгаалагч

Агаарын бохирдлын эрсдэлээс сэргийлэх сургалтад асран хамгаалагчдын 76.5 хувь (95%ИХ: 73.6-79.1) нь хамрагдаагүй байна. Харин агаарын бохирдлоос сэргийлэх талаарх сургалтад хамрагдсан асран хамгаалагчдын сургалтынхаа үр дүнгийн байдалд өгсөн сэтгэл

ханамжийн нийт дундаж оноо 3.08 (95%ИХ: 3.0-3.15) буюу "сэтгэл ханамжтай" байлаа. Чанарын судалгаанд хамрагдсан оролцогчид агаарын бохирдлын сургалтад хамрагдсан гэж байгаа ч энэ нь сайжруулсан түлш хэрэглэхтэй холбоотой мэдээлэл байжээ.

Хорооны болон өрхийн эмнэлгээс агаарын бохирдлоос сэргийлэх чиглэлээр сургалтад хамрагдах тухай мэдээллийг авч байсан. Мөн хорооны ажилтнууд айл өрхөөр явж түүхий нүүрсний хор уршиг, цаашид түүхий нүүрс хэрэглэхгүй байх талаар зөвлөгөө, мэдээлэл өгч байсан. Одоогоор хорооны хэмжээнд сайжруулсан түлшийг нэвтрүүлж эхлээгүй байгаа. Энэ жилээс хэрэгжүүлж эхлэнэ гэж найдаж байна.

СХД-ийн иргэн Н

Судалгаанд оролцогчдын 29.8 хувь нь эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн самбараас агаарын бохирдлоос сэргийлэх талаар мэдээлэл авсан байлаа.

Чанарын судалгаанд оролцсон цөөн оролцогчид хүчилтөрөгчийн коктейл уух нь агаарын бохирдлоос сэргийлдэг гэсэн буруу ойлголттой байгаа нь харагдсан. Судалгаанд хамрагдсан хүн амын 31.4 хувь нь агаарын бохирдлоос сэргийлэхийн тулд амьдарч, ажиллаж байгаа орчноо өөрчлөх боломжгүй гэж хариулсан нь бусад хүндрэлүүдээс статистик ач холбогдол бүхий ялгаатай байв (Figure 1).




Figure 1. Difficulties in preventing air pollution, by percentage of participants

Чанарын судалгаанд хамрагдсан асран хамгаалагчид агаарын бохирдлоос сэргийлэхийн тулд хүүхдийн дархлааг ямар хоол тэжээлээр сайжруулж болох талаар зөвлөгөө шаардлагатай байдаг гэжээ.

Хооллолтын зөвлөгөө өгөөд байдаггүй. Бидэнд мэдээлэл байхгүй болохоор уламжлалт хэв маягийн дагуу мах, аарц, шөлтэй хоол л өвлийн улиралд өгдөг дөө.

3 настай хүүхдийн ээж Б, Баянхонгор аймаг

Агаарын бохирдлоос сэргийлэхийн тулд хоол хүнстэй холбоотой зөвлөгөө авч байгаагүй. Энэ талаар илүү дэлгэрэнгүй мэдэх сонирхолтой байна.

БЗД-ийн 6 сартай хүүхэдтэй ээж

зөвлөгөө, мэдээллүүд өвлийн улиралд илүү хэрэгцээтэй байдаг гэжээ.

Зөвлөгөө, мэдээлэл сайн өгөх хэрэгтэй. Ард иргэд үүний дагуу арга хэмжээнүүдээ авч чадна. Өвлийн улиралд гэрээ нүүлгээд явж чадахгүйгээс хойш энэ муухай утаанаас хүүхдээ хамгаалах аргуудыг хэрэгжүүлнэ шүү дээ.

10 сартай хүүхдийн ээж С, Баянхонгор аймаг

Хэлцэмж

Судалгаанд оролцогчид өрх, дүүргийн эрүүл мэндийн төвийн (i) үйлчилгээ, (ii) үйл ажиллагаанд “сэтгэл хангалуун”, харин өрх, дүүргийн эрүүл мэндийн төвийн (iii) автомашины зогсоол, ариун цэврийн өрөөний орчин нөхцөлд “сэтгэл дундуур” үнэлгээг өгсөн нь Linlin Hu, Hui

Ярилцлагад хамрагдсан асран хамгаалагчид агаарын бохирдлоос хүүхдээ хэрхэн сэргийлэх

Ding нар (2019)-ын судлаачдын судалгаатай дүйж байна. Энэхүү судалгаагаар БНХАУ-ын 31 мужийн 136 гуравдугаар шатлалын эмнэлгийн амбулаториор үйлчлүүлсэн 28822 үйлчлүүлэгчдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн түвшинг Лайкертын 1-5 хүртэлх оноогоор үнэлж, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг тодорхойлжээ. Судалгаагаар эмчийн ур чадварт сэтгэл ханамжтай байсан бол эмнэлгийн хүлээлгийн цаг, орчин нөхцөл тухайлбал ариун цэврийн өрөө, ундны усны хангамжийн ариун цэвэрт сэтгэл ханамж дундуур байгаагаа илэрхийлсэн байна [14]. Мөн Жордан улсад 2017 онд хийгдсэн судалгаагаар амбулаториор үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжид эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар нөлөөлдөг болохыг тодорхойлсон байдаг [15].

Түүнчлэн Хайпин Чен, Мейна Ли нар (2016)-ын БНХАУ-ын Шанхай хотын улсын эмнэлгүүдэд хэвтүүлэн эмчлэх үйлчилгээ, хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжид нөлөөлдөг хүчин зүйлүүдийн талаарх судалгаагаар судалгаанд хамрагдагсдын 89.75% нь эмнэлэгт хэвтэх үедээ авсан үйлчилгээндээ сэтгэл хангалуун байсан ба 0.57% нь сэтгэл дундуур байгаагаа илэрхийлсэн байна. Харин сэтгэл ханамжид сарын орлого, гэр бүлийн байдал тийм ч нөлөөтэй биш гэдгийг тодорхойлсон бөгөөд эмч, сувилагчдын харилцаа хандлага, түүнээс гадна эмнэлгийн орчин нөхцөл, эмнэлгийн үйлчилгээний зардал нь хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшинд нөлөөлдөг ба магадлалын харьцаа 2.43, 3.19, 2.72 байна [16]. Энэхүү судалгаагаар эмч, сувилагчдын харилцаа хандлага, эмнэлгийн орчин нөхцлийг сайжруулснаар, мөн эмнэлгийн үйлчилгээний зардлыг нэмэгдүүлснээр эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлэх боломжтой гэдгийг зөвлөжээ. Эрүүл мэндийн байгууллагууд нь тусламж, үйлчилгээний чанарт анхаарахын зэрэгцээ үйлчлүүлэгчтэй харилцах харилцаа болон эмнэлгийн орчинг сайжруулан ажиллах нь чухал байгааг харуулж байна.

2019 онд хийгдсэн Улаанбаатар хотын БЗД, СХД болон Баянхонгор аймгийн 532 эмч мэргэжилтний агаарын бохирдлын талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх судалгаагаар оролцогчдын 86.8 хувь нь агаарын бохирдлын өртөлтийг хэрхэн тогтоож, зөвлөгөө өгөх талаарх ямар нэгэн сургалтад огт хамрагдаж байгаагүй гэжээ. Ярилцлагад хамрагдсан эмч нарын дийлэнх нь ид ачаалалтай байх үед

бага насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн үзлэг, дархлаажуулалт, хөнгөлөлттэй эмийн жор бичүүлж авахаар ирсэн үйлчлүүлэгч ихтэй байдаг тул агаарын бохирдлоос сэргийлэх зөвлөгөө өгөх зав байдаггүй гэсэн байна [12]. Харин бидний судалгаанд хамрагдсан асран хамгаалагчдын 76.5 хувь агаарын бохирдлын эрсдэлээс сэргийлэх сургалтад мөн хамрагдаагүй байлаа.

Дүгнэлт

Иргэд өрх, дүүргийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээ, үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байдаг бол өрх, дүүргийн эрүүл мэндийн төвийн гадна орчинд автомашины зогсоол байхгүй, ариун цэврийн өрөөний орчин нөхцөлд сэтгэл дундуур байдаг байна.

Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд агаарын бохирдлын өртөлтөөс урьдчилан сэргийлэх аргуудын талаар сургагдаагүй тул 0-5 насны хүүхэдтэй асран хамгаалагч нарт сэтгэлд нийцсэн зөвлөгөө өгч чаддаггүй болохыг тоон болон чанарын судалгаагаар тогтоолоо.

Талархал

Энэхүү ажлыг гүйцэтгэхэд санхүү, техникийн туслалцаа үзүүлсэн Швейцарийн хөгжлийн агентлаг, Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн “Агаарын бохирдлын эх, хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг бууруулах нь” төслийн хамт олонд талархал илэрхийлье.

НОМ ЗҮЙ

1. 2011 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2
2. “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны аргачлал батлах тухай”. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 13 тоот тушаал.
3. ЭМЯ-ны харьяа байгууллагуудын Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, 2018.
4. Бага насны хүүхдийн цогц хөгжил, 2020, НҮБ-ын Хүүхдийн сан
5. Эрүүл мэндийн үзүүлэлт, ЭМХТ, 2019.
6. Хүүхдийн өвчний цогц менежмент, 2020
7. Kim Mullholland et al, Pneumonia in children in Ulaanbaatar and the potential for mitigation, 2012 International expert consultation on: “Understanding and addressing the impact of Air Pollution on Child Health in Mongolia, 2016

8. А.Энхжаргал, Б.Сувд, Б.Бурмаажав нар. Агаарын бохирдол, түүний хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судалсан дүн. Нийгмийн эрүүл мэндийн онол, практикийн 2-р бага хурлын эрдмийн бүтээлийн товчоон. 2012, х.160-162
9. НҮБ-ын Хүүхдийн Сан (2017) Агаар дахь аюул: Агаарын бохирдол бага насны хүүхдийн тархины хөгжилд нөлөөлөх нь
10. Олон нийтэд түшиглэсэн хүүхдийн өвчний цогц менежментийн дэмжлэгт хяналт тандагчийн гарын авлага, ЭМЯ, ЭХЭМҮТ, НҮБХС, 2019 он
11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны чиглэл (2018-2022). Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/514 тоот тушаал.
12. Отгонбаяр Д, Цэгмэд С, Сувд Б болон бусад. “Агаарын бохирдлын талаарх эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, хандлага, дадал судалгааны дүнгээс” . Монголын Анагаах Ухаан, 2020-3 (193).
13. Winning the Fight Against Air Pollution in Ulaanbaatar. NO.2018-1. Asian Development Bank. DOI: <http://dx.doi.org/10.22617/BRF189786-2>
14. Linlin Hu, Hui Ding, BA et al. “How perceived quality of care affects outpatient satisfaction in China: A cross-sectional study of 136 tertiary hospitals”, The evolution of the hospital market in China-Original Research, 2019
15. Health Care Service Quality and Its Impact on Patient Satisfaction “Case of Al-Bashir Hospital” International Journal of Business and Management; Vol. 12, No. 9; 2017, ISSN 1833-3850 E-ISSN 1833-8119
16. Haiping Chen, Meina Li et al. “Factors influencing inpatients’ satisfaction with hospitalization service in public hospitals in Shanghai, People’s Republic of China”, Patient Preference and Adherence 2016:10 469–477

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Анагаах ухааны доктор Г. Цэцэгдарь*